



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/153

Чингис хот

Барилгын ажлын бодит гүйцэтгэлийг  
баталгаажуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4-ийн "а" дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 1500 суудалтай сургуулийн барилгын ажилтай холбогдох маргаан Улсын дээд Шүүхээс эцэслэн шийдвэрлэгдсэн тул тус барилгын ажлын бодит гүйцэтгэлийг баталгаажуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүдэд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын Ерөнхий инженер

Зураг төслийн зохиогчийн төлөөлөл

Гүйцэтгэгчийн төлөөлөл

2. Ажлын хэсгийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, бодит гүйцэтгэлийг шуурхай баталгаажуулахыг ажлын хэсгийг ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010420